



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 5/163

Улаанбаатар хот

Э.Оюунтунгалагийг төрийн албанаас чөлөөлж,  
нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 9.6.9 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2, 46.3, 60 дугаар зүйлийн 60.1, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”, “Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай” хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Зам, тээврийн хяналтын хэлтсийн Зорчигч тээврийн хяналт хариуцсан шинжээч Эрдэнийн Оюунтунгалагийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн төрийн албанаас чөлөөлсүгэй.

2.Э.Оюунтунгалагийн албан тушаалын нэг сарын үндсэн цалин болох 1,436,488.0 (нэг сая дөрвөн зуун гучин зургаан мянга дөрвөн зуун наян найм) төгрөгийг төрийн албанд ажилласан 33 жилийг нь харгалзан 33 сараар үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгосугай.

3.Буцалтгүй тусламжид шаардагдах 47,404,087.0 (дөчин долоон сая дөрвөн зуун дөрвөн мянга наян долоо) төгрөгийг зохих сангаас олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Ренчиндамба)-т зөвшөөрсүгэй.

4.Э.Оюунтунгалагийн ажлыг зохих журмын дагуу хүлээлцүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (А.Мөнхбат)-т, холбогдох санхүүгийн тооцоог хийж дуусгахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Ренчиндамба)-т тус тус үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА С.БАТБОЛД



080001119